

XX зууны 20-иод оны эхээр Монголд албан хэргээр очсон
герман дипломатч нарын зарим тэмдэглэлээс

Доктор, профессор Ута Шене
/Берлин хот/

1920-иод онд нэлээд хэдэн герман хүн Монголд очиж байлаа. Тэдний дотор 1922 оны дундуур Герман улсаас Хятад болон Зөвлөлт-Орос Улсад суугаа элчин, консулын газарт алба хааж агсан хоёр дипломатч Hermann Gipperich, Dr. Asmis нар Гадаад Монголд аялан очсон билээ. Gipperich бол орос, монгол хэлтэй бөгөөд мөн онд Бээжинд суугаа Германы элчингийн газарт дэд консулаар ажиллаад удаагүй байв. Тэрбээр VI сарын 27-ны өдөр Чуулалт хаалганаас гарч Замын-Үүдэд 2 хоноод, улмаар Нийслэл хүрээнд VII сарын 1-нд хүрэлцэн ирж, VIII сарын 8-ны өдөр Монгол улсын нийслэлээс Бээжин рүү эргэн буцсан ажээ. Харин Asmis бол Москва хотод суугаа Германы элчин яамны зөвлөхөөр алба хаахдаа түр хугацаагаар Дорнод Сибирийн байдалтай танилцах зорилгоор Чита хотод очиж ажиллаад тэндээс мөн оны VIII сарын 2-нд Нийслэл Хүрээнд ирсэн байна. Тухайн үеийн түүхийн гэрч болох тэр хоёр хүний бичсэн аян замын тэмдэглэл, Германы Гадаад яаманд илгээсэн мэдээллийг хураангуйлан авч үзвэл 1920-иод оны эхэн үеийн Монгол орны тухай шинэ баримт сэлт нилээд тусгагджээ. Мөн тэрчлэн гадаадын энэ хоёр хүнд 1922 оны үеийн Монгол орон, монголчуудын тухай ямар сэтгэгдэл, ямар ойлголт /бодитой юм уу хувийн саналын чанартай, үнэн байдалд яг нийцсэн, зөв, буруу ч, алин ч байж болох/ төрсөн бэ? гэвэл ихэнхдээ нэлээд сонин мэдээ тааралдаж байна. Berlin-Lichterfelde хот дахь Bundesarchiv хэмээх Холбооны архивт хадгалагдаж буй энэхүү эх баримтыг миний бие задлан шинжилж дор дурдсан зарим зүйлийг толилуулъя.

H.Gipperich Нийслэл Хүрээнд байх үедээ Зөвлөлт-Оросын төлөөлөгчдийн газрын түр хамаарагч А.Я.Охтины¹ зөвлөснөөр 1922 оны VII сарын 2-3-ны өдөр монгол улсын Ерөнхий сайд Жалханз хутагт Дамдинбазар, Гадаад яамны сайд Цэрэндорж, Сангийн яамны сайд Данзан болон Цэргийн яамны сайд Сүхбаатар нарт анх бараалхжээ. Тэрбээр энэ тухай Германы ГЯЯ-нд бичсэн мэдээлэлдээ “Хаана ч очсон газар яаманд намайг их элэгсэг дотноор хүлээн авч уулзаж ... алс хол оршдог Герман орныг машид сонирхожбайгаагаа илэрхийлж байлаа”² гэж тэмдэглэжээ. Цаашид уулзан ярилцсан монгол сайд нарыг тус тусад нь тодорхойлон дурдахдаа: “Ерөнхий сайд Жалханз гэгээнтэн бол шашны язгууртан хүн бөгөөд Өргөөнд Богд хааны дараахь байранд ордог. Тэрбээр бичиг үсэг үл мэдэгч боловч /? – У.Ш./ их нэр хүндтэй, эрхэмсэг хүн шиг санагдана. Олон шавьтай, малаар баян энэ хутагтын хүрээ нь Засагт хан аймагт оршдог байна. Энэ буурал хөгшин бол уудам бэлчээртэй төрөлх нутгийнхаа энх амгалан аж амьдралыг Өргөө хотын улс төрийн далдуур хөнөөлд нэрвэгдсэн Ерөнхий сайдын эргэлзээтэй ийм албан тушаалаар сольсондоо харамсаж байгаа юм шиг над санагдаж байлаа. Түүнээс огт ондоо зүтгэлтэн гэвэл 1914 онд Орос-Монгол улсын хооронд байгуулсан төмөр замын тухай хэлэлцээрт гарын үсгээ зурсан бөгөөд Монголын шинэ түүхийн улс төрийн ээдрээтэй олон үйл явдалтай учирч байсан боловч нэгэнт хүлээсэн байраа алдаж үзээгүй Гадаад Яамны тэргүүн сайд, Ерөнхий сайдын орлогч, арга зальтай дипломатч, хашир түшмэл Цэрэндорж болно. Тэрбээр монгол, хятад хэл бичигтэй бөгөөд орос хэл бага зэрэг гадарладаг засгийн газрын хамгийн чадамгай /чадвартай/ түшмэл болох нь эргэлзээгүй. Харин Сангийн яамны сайд Данзан бол ард гаралтай хүн юм. Тэрээр улс төрийн янз бүрийн эргэлтийн давалгаанаар өндөр

¹ Оросын түр хамаарагчийн гүйцэтгэдэг үүргийг тодорхойлон бичсэн нь: “Гадаадын албан ёсны ганц хоёр төлөөлөгч бол төвд, Зөвлөлт-Орос улсын төлөөлөгч юм. Далай ламын төлөөлөгч нь зөвхөн шашны талаар тодорхой үүрэг гүйцэтгэдэг байхад орос түр хамаарагч улс төр, цэрэг, эдийн засгийн хувьд нөлөөтэй байна. Иймээс түүнийг Монголыг жинхэнэ ноёрхогч нэрлэвэл таарна” гэв. Barch.R 9208/2359, Bl. 123.

² Barch.R 9208/2359, Bl. 124.

тушаалтанд дэвшсэн аж. Данзан үйл хэрэгтээ чин үнэнч зүтгэж байгаа боловч тэр хэцүү алба тушаалдаа арай тохироогүй байх. – Дараа нь би Цэргийн яамны сайд Сүхбаатар, Шүүхийн яамны сайд Магсаржав, Дотоод яамны сайд Сэцэн хантан нартай танилцав. Тэр гурвын дотроос онцгой хэв шинжтэй хүн бол Цэргийн яамны сайдын алба тушаалтай эрэлхэг цэрэг, зоригтой залуу Сүхбаатар юм. Ихэнх яаманд орос зөлөгч ажилладаг. Тэд их нөлөөтэй, бас оросын ашиг сонирхолд нийцэхгүй аль ч асуудлаас урьдчилан сэргийлж байдаг.”³ Gipperich VIII сарын 1-нд /наадмын үеэр/ болсон цэргийн жагсаалт, биеийн тамир, морины уралдааныг үзэж сонирхсоноо тэмдэглэхдээ “Цэргийн яамны сайд өөрөө оролцож, казак морин цэргийн маягийн уран тоглолтыг үзүүлэв.”⁴ гэжээ. Бодоо нарыг баривчилсан тухай товч мэдээ Gipperich-ийн тэмдэглэлд бас бий. Үүнд: “Өргөөн байсан миний хамгийн сүүлчийн өдрүүдэд улс төрийн нууцгай явууллага гэгчид холбогдон 26 хүн, тэдний дотор Ерөнхий сайд агсан Бодоо, английн Zegera & Co. Пүүсийн орос захирал зэрэг нөлөө бүхий хүн баригджээ. Гэтэл тэднийг буруутгах шалтгааныг тодруулан сонсч чадсангүй. Энэ нь Госполитохрана /дотоодыг хамгаалах газар – У.Ш./ -гийн үйл ажиллагаатай холбоотой хэвийн нэгэн үзэгдэл мөн билээ.”⁵ гэжээ.

Gipperich уг нь 2-3 долоо хоногийн дараа харих төлөвлөгөөтэй ирсэн боловч Нийслэл Хүрээнд байх хугацаагаа сунгах хэрэг гарсан. Учир нь герман дипломатч Asmis-ийг Чита хотоос Монгол руу гарсан тухай мэдээ авчээ. Нөгөө хүнийг Хүрээнд хүрэлцэж иртэл Gipperich цам бүжиглүүлэх ёслолыг үзэж, Богд хаан, эх дагина нарт бараалхсан. Үүний тухай нэлээн дэлгэрэнгүй мэдээ бичихдээ “Долдугаар сарын 30-ны үдээс хойш морьтой нэг элч миний байранд ирж, намайг дагуулаад Хүрээ хийдэд хүргэж өгсөн. Тэнд намайг болон орос төлөөлөгч Охтиныг Богд хаантан хүлээн авна гэж хэлэв. ...Бид хоёрыг оруулсан ёслолын гэрт сүм хийдийн зарим ихэс дээдэс, засгийн газрын бүх сайд нар цугларч ирсэн билээ. Гоёмсог хувцас өмсөн Богд хаан өндөр ширээнд бурхан хөрөг шигээ сууж байв. Түүний нүүр царай нь зүүсэн нүдний хөх өнгөт шилээр улам битүү болж, өрдөө сүр сүлдгүй мэт харагдаж байсан. Хөгшрөл, ертөнцийн зугаа цэнгэлийг хэт амссан шинж тэмдгийг далдавчлахаар нүүр царайг нь будсан бололтой. Богд хааны зүүн талд нь адилхан нэгэн ширээнд гэргий нь⁶ мөн байдлаар сууж байв. Хоёр өвдгөө сөгдөхөөс Охтин бид хоёр эрс татгалзсан учир босоо зогсож үг хэлэхийг зөвшөөрсөн. Оросын түр хамаарагчийн үг хэлсний дараа Богд хааны нэрийн өмнөөс Ерөнхий сайд хариулсан. Түүний хэлсэн үгийн утга агуулгыг нь хураангуйлвал Германы ард түмний төлөөлөгч Таны манай баяр наадамд оролцсонд би их баярлаж байна. Харийн дарлалаас чөлөөлсөн манай ард түмэн бат бэх найрамдал, худалдааны харилцаа тогтоохыг эрмэлзэж байна. Иймийн тулд германы ард түмэн монголын ард түмэнтэй байнгын холбоо харилцааг тогтоож өрнүүлэн хөгжүүлнэ гэдэгт найдаж байна гэж хэлсэн. Дараа нь Богд хаан, хатан нартай хадаг барилцаж, ингээд энэ ёслолыг дуусгав.”⁷ гэжээ.

Монголын тал 1922 онд хоёр улсын худалааны тухай хэлэлцээр байгуулахыг хүссэн бас нэгэн баримтыг Gipperich-ээс ГЯЯ-ндаа мөн онд илгээсэн нууц захидлаас нь үзэж болно. үүнд бичихдээ “Ерөнхий сайд Жалханз хутагт Дамдинбазар намайг харихаасаа өмнө дахин хүлээн авч уулзаж, Монголын нийт засгийн газрынхны өмнөөс Герман, Монгол хоёр улсын хооронд худалдааны хэлэлцээрийг хийх эрмэлзэлтэй байгаагаа дахин илэрхийлсэн билээ.”⁸ Гэвч энэ удаа зөвхөн эдийн засгийн талаар

³ Ebenda /мөн тэнд/, Bl. 125.

⁴ Ebenda , Bl. 128.

⁵ Ebenda , Bl. 130.

⁶ Н.Gipperich 1923 онд төгссөн эх дагина Дондогдуламын тухай хожим дурсан бичихдээ “Уран ухаантай, арга зальтай, зоригтой энэ эмэгтэй нас барснаас хойш богд хааны ордны эрх хүч ихээхэн суларсан байна” /Barch, R 9208/2359, S.34/. Энэ дүгнэлт нь 1926 онд бичсэн орос дипломатч И.Я.Коростовецийн саналтай яг нийлсэн байна.

⁷ Ebenda , Bl. 127-128.

⁸ Ebenda , Bl. 299.

мэдээлэл авахаас өөр ямар нэгэн албан ёсны даалгавартайгаар Монголд ирээгүй болохоор хэрэг бүтэлтэй болсонгүй.

Хэдхэн хоногийн дараа тухайлбал VIII сарын 5-ны өдөр Ерөнхий сайд, Гадаад болон Цэргийн яамны сайд нарт бараалхсан герман дипломатч Asmis Монголын талын дээрх хүсэлтийг дахин нотолж өөрийн тэмдэглэлдээ “Монгол нийгмийн бүх давхрааны нийтлэг нэгэн шинж бол Германтай найртай төдийгүй манай улсад элэгсэг дотно угтаж авч ярилцсан. Бас иймэрхүү байдалтай хүлээн авч уулзах байх гэж горьдсон гадаадын зарим худалдаачид өөрийгөө герман хүн хэмээн танилцуулсан тохиолдол бий” гэж бичжээ. Мөн тэмдэглэлдээ Ерөнхий сайд, Гадаад, Цэргийн яамны сайд нартай хийсэн уулзалт, яриагаа онцлон дурдаад цаашид бичихдээ “...гурван цаг гаруй үргэлжилсэн энэхүү уулзалтанд Монголын сайд нар германы пүүсийн тоо улам нэмэгдэж, тэдний тусламжтайгаар Монгол оронд аж үйлдвэрийг нээн хөгжүүлэх талаар дэмжлэг үзүүлэхийг надаас дахин дахин хүсч байв. Түүнчлэн Ерөнхий сайд эдийн засгийн харилцаа холбоо тогтоож эхлэх, нөхцөл байдалтай нь танилцах зорилгоор өөрийн төлөөлөгчдийг Герман улсад явуулах талаар Засгийн газраас шийдвэр гаргалаа гэж над албан ёсоор мэдэгдэв. Урьдах өдөр бас Цэргийн яамны сайд энэ тухай надад ярьж байсан. Энэ асуудлыг зарчмын хувьд аль хэдийн шийдвэрлэсэн боловч төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд хэн хэнийг оруулах, хэдийд явуулах талаар одоо болтол тодруулан өгсөн зүйл арай үгүй байна ... Хожим би өөр нэгэн сурвалжаас Ерөнхий сайд, буриад Ринчино нарыг явуулахаар тогтсон гэж сонсов...”⁹ гэж тэмдэглэжээ. Asmis-ийн тэмдэглэлээс авч үзвэл дээр дурдсан уулзалтын үед бас гэрэл зураг нь одоо аль нэгэн архивт хадгалагдаж байгаа болов уу?

Тэр үед герман, монголын тал шинжлэх ухаан, соёлын талаар нэгэн сонин төслийг боловсруулах, хамтран ажиллах асуудлыг хөндөж хэлэлцсэн билээ.¹⁰ тухайлбал эрдэмтэн Ж.Цэвээний санаачлагаар Европын шинжлэх ухааны нэвтэрхий толийг монгол хэлэнд орчуулж, Leipzig хотын Insel-Verlag хэмээх хэвлэлийн газарт хэвлүүлэн гаргах санаатай байв. Харин Монголын засгийн газар герман ажилтны хөлсий нь төлөхөөс татгалзсан болохоор эл төслийг хойшлуулсан нь харамсалтай. Мөн тэрчлэн малын тахал өвчинтэй тэмцэх зорилгоор германы малын их эмч нарыг ирүүлэх тухай ярилцсан байна. Энэхүү төслийн биелэлт мөн адил Монголын засгийн газраас зохих хөрөнгө гаргаж чадах эсэхээс шалтгаалсан билээ. Монголд археологийн малталт хийлгэхээр герман археологичдыг ирүүлж өгөхийг хүссэн. Германы тал энэ хүсэлтийг нааштай хүлээн авсан боловч хэрхэн хэрэгжүүлсэн тухай тодорхой мэдээ олдохгүй байна.

Gipperich Чуулалт хаалганаас Нийслэл Хүрээ рүү явахдаа америкийн автомашины үйлдвэрийн 4 цилиндртэй Dodge машинд сууж явсан байна. Энэ нь говь хээрийн замаар явахад маш тохиромжтой учраас тэр үед голдуу унаж байсан автоамшин гэнэ. 1083 км урт замын зардал 100 орчим ам.долларын үнэтэй байлаа. Хээрийн зам тийш муу биш болохоор 50 км-ийн хурдтай явсан тохиолдол олонтой гэжээ.¹¹

Түүнчлэн Gipperich-ийн аян замдаа хийсэн зарим сонин ажиглалт гэвэл Чуулалт хаалганы араа монголчуудын уугуул бэлчээр нутагт хятадын иргэн тариачдыг шилжүүлэн суулгаж атар хагалуулсан явдал юм. Тэрбээр бичихдээ “Монголчуудын эртний хот Хар балгасны үлдэгдлийг эргэн тойрон одоо тариалангийн талбай байв. ...Ингэхлээр Хятадын цэргийг Монголын нутгаас дахин дахин хөөж гаргасаар байхад хятад тариачид арав, арваад жилийн турш Монголыг холгон эзэмшсээр байна. Хятадын эрх баригчид Монгол орныг цэргийн хүчээр улс төрийн байнгын эрхшээлд оруулж чадахгүй. Гэвч хятадын тариачид, гар учрууд, худалдаачид тэр орныг цус урсгалгүйгаар эрхшээлдээ оруулж амжина гэж би бодож байна”¹² гэжээ.

⁹ Ebenda , Bl.165-166

¹⁰ Ebenda , Bl.1-2

¹¹ Ebenda , Bl. 114-116

¹² Ebenda , Bl. 116-117

Эцэст нь хэлэхэд герман дипломатч нарын тэмдэглэлд дурдсан эдгээр зүйлийг Монгол улсын нэн шинэ түүхийн судлалд өчүүхэн ч гэсэн хувь нэмэр болох байх гэж итгэнэм.